

## ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2019 оны 9 сарын дугаар.

### Тэргүүн мэдээ.

#### ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төслийн үндсэн баримт бичигт гарын үсэг зурав.



9 сарын 26-ны өдөр “ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн (цаашид төсөл гэх) үндсэн баримт бичигт гарын үсэг зурах ёслол болов. 66 сая толгой мал, өргөн уудам эдэлбэр газартай ХАА-н салбарыг хөгжүүлэхдээ үйлдвэрлэл, түгээлт, боловсруулалт, борлуулалтын бүхий л процессийг сайжруулан нэмүү өртгийг нь өсгөх зорилго бүхий нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Иймд ирэх жилийн 1-р сараас 3 жилийн хугацаатай хэрэгжих энэхүү төслөөр Мастер төлөвлөгөө боловсруулахаас гадна 20 орчим туршилтын төсөл хэрэгжүүлэн тэдгээрээс гарсан үр дүн, сургамжийг Мастер төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байна. Энэхүү төсөл эхлэхийн өмнөхөн 10 сарын 22-ны өдөр Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвд “Арьс ширний үйлдвэрлэлийн хөгжил” сэдэвт семинар болно.

### Төслийн хэрэгжилт.

#### “Монгол улсын макро эдийн засгийн төлөвлөлтийн чадавхийг сайжруулах” төслийн үндсэн баримт бичигт гарын үсэг зурлаа.



9 сарын 4-ний өдөр ЖАЙКА болон Сангийн яам “Монгол улсын макро эдийн засгийн төлөвлөлтийн чадавхийг сайжруулах” төслийн үндсэн бичиг баримтад гарын үсэг зурлаа. Энэхүү техникийн хамтын ажиллагааны төсөл нь энэ жилийн эцэсээс эхлэн 3 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд Сангийн яамны Макро эдийн засгийн хэлтсийн ажилтнуудыг чадавхжуулан макро эдийн засгийн таамаг тооцоонд шинжилгээ хийх загварыг боловсронгуй болгож, хэрэглэж хэвшүүлэх юм. Тэрчлэн тогтмол хугацааны тайлан гаргах, шийдвэр гаргагч нарт өгөх бодлогын зөвлөмж боловсруулах чадавхийг нь дээшлүүлэх замаар макро эдийн засгийн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх зорилго тавьж байна.

※Дээрх зураг нь 2019 оны 6 сард болсон нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах судалгааны санамж бичигт гарын үсэг зурах үеийн зураг болно.

#### Инженер технологийн дээд боловсролыг дэмжих төслийн хүрээнд Барилгын материалын туршилт, судалгааны итгэмжлэгдсэн лабораторийн нээлт болов.



9-р сарын 6-ны өдөр Монгол улсын ШУТИС-ийн Барилга архитектурын сургуулийн Барилгын материалын туршилт, судалгааны итгэмжлэгдсэн лабораторийн нээлт болж, ЖАЙКА-ын Төлөөлөгчийн газрын дарга Тамүра Эрико оролцлоо.

Инженер технологийн дээд боловсролыг дэмжих төслийн хүрээнд, ШУТИС-ийн хамтарсан судалгааны 10 багийн нэг болох Барилга архитектурын сургууль ба Тохокү их сургуулийн хамтарсан багийн (Судалгааны сэдэв : Дулааны цахилгаан станцын үнсийг барилгын материалын үйлдвэрлэлд хэрэглэх ногоон ирээдүй) судалгааны тоног төхөөрөмжийг (Үнийн дүн:872950ам.доллар) нийлүүлж, лабораторид суурилууллаа.

Универсаль туршилтын төхөөрөмж, шахалтын туршилтын төхөөрөмж зэрэг 13 төрлийн төхөөрөмжийг ашигласнаар судалгаа шинжилгээ болон сургалт, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаанд шинэ ахиц гарна гэж найдаж байна.

## Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхийг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллого хийх мөчлөгийг тасралтгүй сайжруулах төслийн хамтарсан удирдах хорооны 2-р хуралдаан болов.



9 сарын 19-ний өдөр ТХА-ны “Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхийг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллого хийх мөчлөгийг тасралтгүй сайжруулах төслийн хамтарсан удирдах хорооны 2-р хуралдаан болов. Уг хуралд БОАЖЯ-ны Байгаль орчин, уур амьсгалын сангийн холбогдох албан тушаалтнууд оролцож, хэрэгжиж эхэлсэнээс хойшхи 2 жилийн хугацаан дахь төслийн хэрэгжилтийн байдлын талаар ярилцав. Хурал дээр хүлэмжийн хийн тооллогыг сайжруулах аргачлалын гарын авлага боловсруулах ажил дуусаж, тодорхой үр дүн гарч байгааг мэдээлэхийн хамт тооллогыг сайжруулах ажилд бусад яам агентлагуудаас холбогдох мэдээлэл гаргуулж авах шаардлагатай тул яам агентлаг хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог улам бэхжүүлэх шаардлага байгааг дахин тэмдэглэв.

## Орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад хувь нэмэр оруулах клиникийн нэгдсэн сургалтын эхний үе шат өндөрлөв.



Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслөөр дамжуулан дэмжлэг үзүүлж буй Клиникийн нэгдсэн сургалтын эхний үе шатны хаалтын ёслол 9 сарын 13-ны өдөр Улаанбаатар хотод болов. Монголд анх удаа зохион байгуулагдсан уг сургалтаар резидент эмч нар 1 жилийн хугацаанд дотор, хүүхэд, эх барих эмэгтэйчүүд, яаралтай тусламжийн тасгуудад сэлгэн ажиллаж, орон нутагт шаардагдах эмчилгээ, оношлогооны ур чадварт суралцав. Төслийн загвар эмнэлэг болох Орхон аймаг, Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлэгийн 19 резидент эмч сургалт дүүргэсэн гэрчилгээ гардан авсан байна. Цаашид монголын хөдөө орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад хувь нэмэр оруулахуйц боловсон хүчин болж ажиллана гэж найдаж байна.

## ЖАЙКА-ын сайн дурын(JV) үйл ажиллагаа.

### Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга. (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах эмчилгээний тухай семинар зохион байгуулагдав. )



9 сарын 5,6-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах эмчилгээний тухай семинар болов. Уг семинарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж буй Сасаи Юина сайн дурын гишүүний харьяалагддаг аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс зохион байгуулсан бөгөөд Архангай аймагт хөдөлгөөн засалчаар ажилладаг Ёшино Микико, Улаанбаатар хотод хөдөлмөр засалчаар ажилладаг Окуда Мисаки нар багшаар оролцсон байна. Өвөрхангай аймгийн эмч, сувилагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан ажилтнуудад зориулан зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хооллох үеийн биеийн байрлалыг тохируулах, хоолны хэрэгслийг сайжруулах, гэрт хийх сэргээн засал зэрэг практик агуулгатай уг сургалт оролцогчдоос өндөр үнэлгээ авсан бөгөөд семинараар олгосон мэдлэгийг ажил дээр бодитоор ашиглана гэдэгт найдаж байна.

Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА)

Монгол дахь төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 /E-mail: [mg\\_oso\\_rep@jica.go.jp](mailto:mg_oso_rep@jica.go.jp)

Web: [www.jica.go.jp/mongolia/index.html](http://www.jica.go.jp/mongolia/index.html) /FB: [JICA Mongolia](https://www.facebook.com/JICA Mongolia)